



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 510

Улаанбаатар хот

“Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-д  
хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.8, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 4.8 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-д хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан журмыг үйл ажиллагаандаа чанд баримталж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн явуулахыг “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК /Д.Гантөгс/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000864